

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 дугаар тушаалын
6 дугаар хавсралт

ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН БАЙГУУЛЛАГУУД, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР,
СТАНДАРТ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН Д.ОЮУН-ЭРДЭНИЙН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлт ийн хувь
1	2	3	4	5	6	7	
Зорилт 1. "Жуулчдын аюулгүй байдлыг хангах чиглэлээр олон талт арга хэмжээг мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулна."							
1.	Арга хэмжээ 1.1 Жуулчдыг гэмт хэрэг, зөрчилд өртөхөөс урьдчилан сэргийлэх мэдээ, мэдээллийг байгууллагын сайт, олон нийтийн сүлжээгээр болон үйлчилгээний байгууллагуудаар дамжуулан түгээх.	Түгээсэн мэдээллийн тоо	-	10	"Аюулгүй аялах зөвлөмж" онлайн зөвлөөгөөг https://tourism.ub.gov.mn байгууллагын сайт, https://visitulaanbaatar.net цахим хуудас болон газрын "Нийслэлийн Аялал жуулчлалын газар" фейсбүүкийн пэйж хуудас, зочлох үйлчилгээний үйлчилгээ эрхлэгчдийн фейсбүүк Аялал жуулчлалын боловсрол, Аялал жуулчлалын зар, мэдээ, Аялал Жуулчлалын Хөтөч, Жолооч, Тогооч,Компаниуд, Амралтын газруудын нэгдсэн групп, Гоё амралтын газрууд хаана байна, Улаанбаатар хотын Зочид буудлуудын нэгдсэн мэдээлэл, Тэрэлж амралтын газрууд / terelj amraltiin gazruud / жуулчны бааз, Өргөө дэн буудал эрхлэгчдийн холбоо ТББ, Жуулчны бааз, амралтын газрын нэгдсэн групп, Монголын Явган Алхалтын Холбоо / Mongolian Walking Association Group 9 группүүдэд байршуулж түгээсэн. Фейсбүүк, viber дээр зочлох үйлчилгээний бизнес эрхлэгчдийн групп нээж 600 аж ахуйн нэгжид Жуулчдыг гэмт хэрэг, зөрчилд өртөхөөс	01/02-12/20	100

					урьдчилан сэргийлэх мэдээ, мэдээллийг хүргэсэн. Нийслэлийн нэгдсэн мэдээ мэдээлэл, төрийн үйлчилгээний нэгдсэн https://www.ulaanbaatar.mn/ портал системийн "Онлайн бизнес төв"-ийн "Үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл" цэсэд нэвтэрч зочлох үйлчилгээ эрхлэх хүсэлт гаргасан 310 иргэн, хуулийн этгээдэд жуулчдыг гэмт хэрэг, зөрчилд өртөхөөс урьдчилан сэргийлэх мэдээ, мэдээллийг цахимаар илгээн сурталчилсан.		
2.	Арга хэмжээ 1.2. Жуулчдад хэрэгцээт мэдээ, мэдээллийг хүргэх, эрх зүйн туслалцаа үзүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор "Оюутан цагдаа-2024" арга хэмжээг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулах, тайлагнах.	Үйлчилгээ үзүүлсэн гадаад жуулчдын тоо	Хөтөлбөр ийн хэрэгжилт ийн хувь	30	Жуулчны аюулгүй байдлыг хангах, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, тэднийг хэрэгцээт мэдээ, мэдээллээр хангах, эрх зүйн туслалцаа үзүүлэх зорилгоор Нийслэлийн Цагдаагийн удирдах газар, Монголын Оюутны холбоотой хамтран Нийслэлийн ИТХурлын даргын 2024 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн А/74 дугаар захирамжаар "Оюутан цагдаа-2024" арга хэмжээг 2024 оны 06 дугаар сарын 13-ны өдрөөс 08 дугаар сарын 13-ны өдрийн хооронд 2 сарын хугацаанд хэрэгжүүлэн Улаанбаатар хотын 14 их, дээд сургуулийн 50 оюутан ажилуулсан. Тус арга хэмжээний үр дүнд Цагдаагийн байгууллагын 102 тусгай дугаарт гэмт хэргийн 13, зөрчлийн шинжтэй 3213 дуудлага мэдээлэл өгч, дотоодын 16,178 иргэнд туслалцаа үзүүлэн, гадаадын 17,255 иргэнд хэлмэрчилж, 5 төрлийн 20,500 ширхэг гарын авлага, зурагт хуудас, зөвлөмж, сэрэмжлүүлэг тараан, 2600 хүүхдэд эцэг эхийн утасны дугаар бүхий бугуйвч зүүж, эцэг эх, асран хамгаалагчаасаа төөрсөн 136 бага насны хүүхдийг ар гэрт нь, 5 хүүхдийг Цагдаагийн байгууллагад хүлээлгэн өгч, Монгол орны байгалийн дурсгалт болон түүх соёлын дурсгалт газар, үзвэр үйлчилгээний талаар 5 бүлэг 58 мэдээ, мэдээлэл бүхий QR кодыг гадаадын 16,981 жуулчдад танилцуулан ажилласан.	03/04-08/20	100
3.	Арга хэмжээ 1.3. Хотын хөгжлийн индексийн үзүүлэлтийг сайжруулах ажлын хүрээнд зочид буудал, дэн буудал,	Нийслэл хотын албан татварт	12,736,167.1	10,736,167.1	НИТХурлын 2022 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн 34 дүгээр тогтоолоор батлагдсан "Нийслэлийн нутаг дэвсгэрт худалдаа, үйлчилгээ эрхлэх нийтлэг журам"-д заасны дагуу	01/02-06/20	100

	амралтын газар, жуулчны баазуудад хяналт тавих, зөвлөгөө, үйлчилгээ үзүүлэх замаар и-баримтад холбох ажлыг хамтран зохион байгуулж, нийслэл хотын албан татварт төвлөрөх орлогыг нэмэгдүүлэх.	төвлөрүүлэх мөнгөн дүн	
4	Арга хэмжээ 1.4. Аялал жуулчлалын зочлох үйлчилгээний байгууллага зочид буудал, дэн буудал, амралтын газар, жуулчны баазуудад стандартын үзлэг зохион байгуулах.	Байгууллагын тоо	243

https://www.ulaanbaatar.mn/ портал системийн "Онлайн бизнес төв"-д бүртгэлтэй Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлж байгаа 462 зочид буудал, дэн буудал, 196 амралтын газар, жуулчны баазуудын тоон мэдээ, судалгааг шинэчлэн гаргаж нийслэлийн Татварын газарт хүргүүлсэн. НЗД-ын 2024 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн "Ажлын хэсэг байгуулах тухай" А/146 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангах зорилгоор Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй амралтын газар, жуулчны баазуудын судалгааг ашиглаж НТГ и-баримт олголтыг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулсан. 2024 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар Нийслэл хотын албан татварт 26,506.5 (хорин зургаан тэрбум таван зуун зургаан сая таван зуун мянга) төгрөгийн татварын орлого төвлөрсөн байна.		
Зочлох үйлчилгээний дүрэм, журам, стандартын хэрэгжилтийг ханган зорилгоор Налайх дүүргийн Засаг даргын 2024 оны А/190 дүгээр захирамжаар батлагдсан удирдамжийн хүрээнд холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран 2024 оны 08 дугаар сарын 01-ний өдрөөс 30-ны өдрийг хүртэл хугацаанд Налайх дүүрэгт үйл ажиллагаа явуулж буй 161 зочид буудал, дэн буудал амралт жуулчны баазад хяналт шалгалтыг зохион байгуулсан. Шалгалтад хамрагдсан аж ахуйн нэгжүүдэд Зөвшөөрлийн тухай хууль эрүүл ахуйн тухай, Усны тухай, Хөг суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль Байгаль орчныг хамгаалах тухай хууль болон бусад холбогдох хууль, тэдгээрт нийцүүлэн гаргасан, дүрэм, журам стандартын хэрэгжилтийг хангуулах, үнэлгээ дүгнэлт өгөх, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулж, цаашид авах арга хэмжээ, хууль зүйн зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэн ажилласан. Мөн 2 дахь удаагийн стандартын үзлэгийг НБОГазрын даргын 2024 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн баталсан "Нийслэлийн ногоон бүс,	03/15-11/11	90

5	Арга хэмжээ 1.5.		

усан сан бүхий газрын онцгой болон энгийн хамгаалалтын бүсэд журмын хэрэгжилтийг хангуулах, хяналт шалгалт хийх ажлын хэсгийн удирдамж"-ийн дагуу НАЖГ, НБОГ, Туул голын сав газрын захиргааны хамтарсан ажлын хэсэг 2024 оны 10 дугаар сарын 30-ны өдрөөс 11 дүгээр сарын 11-ний өдрийг хүртэл нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлж байгаа 76 амралтын газар, жуулчны баазуудад хяналт шалгалт хийж мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан. Тус хяналт шалгалтын үр дүнгээр үйл ажиллагаа эрхлэгч аж ахуй нэгж нь "Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль"-ийн 7 дугаар зүйлийн 7.2, 7.3 болон 9 дүгээр зүйлийн 9.1, 9.2, 9.6, 9.7 дахь, "Усны тухай хууль"-ийн 28 дугаар зүйлийн 28.4 болон 29 дүгээр зүйлийн 29.1 дахь, "Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль"-ийн 4 дүгээр зүйлийн 4.5 дахь хэсэг болон бусад холбогдох хууль, дүрэм, журмын хэрэгжилт сул байгаа нийтлэг зөрчил, дутагдал илэрсэн. Иймд баримт бичгийн бүрдлийг хангаж, эрх бүхий байгууллагаар дүгнэлт, зөвшөөрөл, гэрээ, гэрчилгээг гаргуулж, холбогдох хууль, дүрэм журам, стандартын хэрэгжилтийг хангаж ажиллах шаардлагыг нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлж байгаа амралтын газар, жуулчны баазуудын захиргаанд хүргүүлсэн. 2024 оны 11 дүгээр сарын байдлаар зочид буудал, дэн буудлын үйл ажиллагаатай холбоотой иргэдээс ирсэн 4 өргөдөл гомдлын дагуу "Зочид буудал, дэн буудал, амралтын газар тавигдах ерөнхий шаардлага (MNS 4588:2008, MNS 6043:2019 стандартын үзлэг хийж Гоулд констракшн ХХК-ийн Гоулд зочид, Зайсан гейт, ЖИ ПИ ПИ ЭМ ХХК-ийн Маргад, Бишрэлт гүн буудлын захиргаанд албан бичиг хүргүүлсэн. "Амралтын газар, жуулчны бааз, гэр буудалд тавих ерөнхий шаардлага" MNS6043:2019, "Зочид	01/02-12/10	100
--	-------------	-----

	Үндэсний болон хотын стандартуудыг иргэд, олон нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулах.				буудалд тавих ерөнхий шаардлага MNS 4588:2008", "Аялал жуулчлал.Дэн буудлын ерөнхий шаардлага MNS 5738:2007", "Амралтын газар, жуулчны баазын гадна болон дотоод орчны тохижилт, зохион байгуулалтад тавигдах ерөнхий шаардлага UCS1203:2022" стандартыг https://tourism.ub.gov.mn байгууллагын сайт, "Нийслэлийн Аялал жуулчлалын газар" фэйсбүүкийн пэйж хуудас, зочлох үйлчилгээний үйлчилгээ эрхлэгчдийн фэйсбүүк Аялал жуулчлалын боловсрол, Аялал жуулчлалын зар, мэдээ, Аялал Жуулчлалын Хөтөч, Жолооч, Тогооч,Компаниуд, Амралтын газруудын нэгдсэн групп, Гоё амралтын газрууд хаана байна, Улаанбаатар хотын Зочид буудлуудын нэгдсэн мэдээлэл, Тэрэлж амралтын газрууд / terelj amraltiin gazruud / жуулчны бааз, Өргөө дэн буудал эрхлэгчдийн холбоо ТББ, Жуулчны бааз, амралтын газрын нэгдсэн групп, Монголын Явган Алхалтын Холбоо / Mongolian Walking Association Group 9 группүүдэд байршуулж түгээсэн. https://www.ulaanbaatar.mn/ портал системийн "Онлайн бизнес төв"-д бүртгэлтэй Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлж байгаа 462 зочид буудал, дэн буудал, 196 амралтын газар, жуулчны баазуудын удирдах ажилтнуудад цахим хаяг, фэйсбүүк хаягаар үндэсний болон хотын стандартуудыг цахимаар илгээн сурталчилсан. Зочлох үйлчилгээний стандартыг нийт 130.000 хүн цахимаар үзсэн.		
Зорилт 2. "Нийслэлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх арга хэмжээ"-г боловсруулж, хэрэгжүүлнэ"							
1.	Арга хэмжээ 2.1. Аялал жуулчлалын салбарын ажилтнуудын ур чадварыг дээшлүүлэх, үйлчилгээний чанарыг сайжруулах	Сургалтад хамрагдсан ажилтнуудын тоо	647	100	Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлж байгаа жуулчны үйлчилгээний байгууллагын удирдлага, ажилчдад зориулсан сургалтыг Аялал	05/03-12/10	100

	чиглэлээр болон олон улсын туршлагыг судлах, экспертийн төрөлжсөн сургалтуудыг зохион байгуулах.				Жуулчлалын Мэргэжлийн холбоо, "Эксперт Хоспиталити" ХХКомпанитай хамтран 2024 оны 05 дугаар сарын 06-09-ны өдүүдэд зохион байгуулсан. Сургалтыг БНСУ-ын СЭЖУН их сургуулийн Зочлох үйлчилгээний Профессор (Ph.D) Kyu Sun Kang, Зоогийн газрын үйлчилгээний доктор багш Lee Mi-young нар удирдан явуулсан. Тус сургалт нь зочлох үйлчилгээний байгууллагуудын хэрэгцээ шаардлагад үндэслэн Зочид буудлын үйлчилгээ, Зоогийн газрын үйлчилгээ гэсэн хоёр төрөлтэй, захирал, менежерүүд болон үйлчилгээний ажилтнууд гэсэн хоёр түвшинд явагдсан. Сургалтад нийт 26 байгууллагын 140 хүн хамрагдаж чадавхажсан.		
2.	Арга хэмжээ 2.2. Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлж буй хоол үйлдвэрлэл, зочлох үйлчилгээний байгууллагууд, зоогийн газрын тогооч нарыг аялал жуулчлал өндөр хөгжсөн оронд туршлага судлуулах ур чадварыг дээшлүүлэх сургалтад хамруулах.	Сургалтад хамрагдсан тогооч нарын тоо	0	40	Зочлох үйлчилгээний салбарын хоол, зоогоор үйлчилдэг хоолны газрыг олноор бий болгож, хоолны нэр төрлийг нэмэгдүүлэх, жуулчинд үйлчлэх мэргэжлийн чадварлаг тогооч нарыг бэлтгэх зорилгоор олон үндэстний хоолны тогооч бэлтгэх "Гастро аялал 2024" сургалтын хөтөлбөрийг НЗДТГ, Монголын ресторан зоогийн газрын холбоотой хамтран хэрэгжүүлсэн. 2024 оны 03 дугаар сарын 09-ны өдрөөс 05 дугаар сарын 09-ны өдөр хүртэл хугацаанд Тайланд, Узбекистан, Хонг Конг, Турк, БНСУ, ОХУ зэрэг улс оронд 50 тогоочийг сургасан. Тэдгээр тогооч нар 240 гаруй хоолыг жорын дагуу хийж сурсан.	02/02-05/10	100
3.	Арга хэмжээ 2.3. Гадаадад суралцаж ирсэн тогооч нар сурсан зүйлсээ хуваалцаж зочлох үйлчилгээний байгууллагуудын тогооч нарт мэдлэгээсээ хуваалцаж сургах ажлыг зохион байгуулах.	Сургалтад хамрагдсан тогооч нарын тоо	-	100	"Гастро аялал 2024" сургалтын хөтөлбөрийн гадаад сургалтуудад суралцсан тогооч нар Улаанбаатар хотын зочлох үйлчилгээний байгууллагууд, зоогийн газрын тогооч нарт сурсан мэдлэг туршлагаа хуваалцах "Олон улсын хоолны хоолны жор технологи" сэдэвт дотоодын сургалтыг 2024 оны 5 дугаар сарын 14-16-ны өдрүүдэд Крокус эвэнт холл-д зохион байгуулж 250 орчим тогооч, багш нар хамрагдаж,	05/02-10/10	100

					суралцсан хоолныхоо амталгааг хийж, 200 төрлийн хоолны технологи картыг англи, монгол хэлээр авсан. Дотоодын сургалтад давхардсан тоогоор хамрагдсан 250 хүн хамтран ажилладаг тогооч нартаа дунджаар 3-10 хүнд зааж сургана гэж тооцоход дунджаар 750-2500 тогоочид хөтөлбөрийн үр шимийг хүртсэн. Зочлох үйлчилгээний байгууллагуудын хүсэлтээр Монголын ресторан зоогийн газрын холбоотой хамтран 2024 оны 10-р сарын 02-ны өдөр Крокус эвэнт холл-д 2 дахь сургалтыг зохион байгуулж хоол үйлдвэрлэл үйлчилгээний салбарын 200 тогоочийг хамруулж Узбек, Европ, Зүүн өмнөд Азийн 22 нэр төрлийн хоол, 6 төрлийн зууш хийх технологи ажиллагаа арга аргачлалд сургасан.		
4.	Арга хэмжээ 2.4. "UB Food Festival" арга хэмжээг зохион байгуулах.	Арга хэмжээний гүйцэтгэл	100	-	Монголын үндэсний хоол болон олон үндэсний хоолны соёлыг гадаад, дотоодын иргэд, жуулчдад сурталчлан таниулах "UB FOOD FESTIVAL-2024" арга хэмжээ 2024 оны 08 дугаар сарын 23-25-ны өдрүүдэд жанжин Д.Сүхбаатарын талбайд зохион байгуулсан. Тус арга хэмжээнд ресторан, зоогийн газар, кофе шоп, хоол үйлдвэрлэл, үйлчилгээний 40 байгууллагыг шалгаруулж оролцуулсан. Аж ахуйн нэгжүүд 3 өдрийн туршид иргэд, жуулчдад Монгол үндэсний болон Европ, Япон, Солонгос, Мексик, Чех, Энэтхэг, Хятад, Узбек хоол зоогоор үйлчилсэн. Шилдэг тогооч нарын онцгой хоолны үзүүлбэр, циркийн үзүүлбэр, амьд хөгжмийн болон урлагийн тоглолт, улс орнуудад уламжлал болтлоо хөгжсөн хоолны тэмцээнүүд зохион байгуулагдсан. 2024 оны "UB food festival" арга хэмжээний онцлог нь Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн санаачлаагаар зочлох үйлчилгээний салбарын хоол, зоогоор үйлчилдэг	03/02-08/27	100

					хоолны газрыг олноор бий болгож, хоолны нэр төрлийг нэмэгдүүлэх, жуулчинд үйлчлэх мэргэжлийн чадварлаг тогооч нарыг бэлтгэх зорилгоор “Олон үндэстний хоолны тогооч бэлтгэх” хөтөлбөрт хамрагдаж Узбекистан, Хонг Конг, БНСУ, ОХУ зэрэг улсад суралцсан тогооч нар олон үндэсний хоолны үзүүлбэр үзүүлж, хийсэн хоолоороо иргэд, жуулчдыг дайлсан. Мөн тус фестивальд оролцогч аж ахуйн нэгжүүдээс “Шилдэг байгууллага”, “Шилдэг тогооч”-ыг шалгаруулж урамшуулсан. Уг эвент арга хэмжээнд 25.000-27.000 мянган дотоодын иргэд, 20 гаруй орны тухайлбал Англи, АНУ, Тайвань, Филиппин, Чех, ОХУ, Австрали, Казахстан, Тажикстан, БНСУ, Япон, Лаос, Вьетнам, Франц, Итали, Испани, Голланд зэрэг улсын 1800 гаруй жуулчид оролцсон. Олон улсын аялал жуулчлалын сургалт судалгааны институттэй хамтран 400 гаруй гадаад, дотоодын иргэдээс сэтгэл ханамжийн судалгаа, оролцогч 40 аж ахуйн нэгжээс зохион байгуулалтын болон үр ашиг орлогын судалгааг авч нэгтгэлээ. Уг арга хэмжээ нь нийслэл хотын төдийгүй зорин ирж буй зочдын сонирхлыг татсан арга хэмжээ болж 10 жилдээ зохион байгуулагдаж оролцогч, үзэгчдийн тоо өмнөх жилийнхээс 2 дахин нэмэгдсэн байна. Арга хэмжээнд оролцсон аж ахуй нэгжүүд 650.000 гаруй сая төгрөгийн бараа бүтээгдэхүүнийг зарж борлуулсан.		
5.	Арга хэмжээ 2.5. “Хүрээ цам даншиг наадам”-ын зохион байгуулалтад оролцох.	Арга хэмжээний гүйцэтгэл	100	-	2024 оны 08 дугаар сарын 03, 04-ний өдрүүдэд “Монгол наадам” цогцолбор буюу Хүй долоо худагт зохион байгуулагдсан “Даншиг наадам-Хүрээ цам” наадмын үеэр иргэдэд үйлчилгээ үзүүлэх хоол үйлдвэрлэл, үйлчилгээний аж ахуйн	08/02-08/04	100

					нэгжүүдийн үйл ажиллагааг зохион байгуулж хяналт тавьж ажилласан. Наадмын арга хэмжээний талбайн тохижилт хийхэд дэмжлэг үзүүлсэн.		
6.	Арга хэмжээ 2.6. Эвент арга хэмжээний зохион байгуулалтад оролцох.	Арга хэмжээнд оролцсон тоо	-	2	"Мазаалай" олон улсын цас мөсний наадам, "Бүргэдийн баяр", "Талын салхи" олон улсын мото наадам, "Плэйтийм" олон улсын хөгжмийн наадам, "Дээлтэй Монгол наадам", "Улаанбаатар өвлийн наадам", "Тэнгэр" олон улсын бөөгийн фестиваль зэрэг эвент арга хэмжээг зохион байгуулахад талбайн тохижилт хийх ажилд оролцсон.	02/02-12/10	100
7.	Арга хэмжээ 2.7. Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхлэж буй зочид буудал, дэн буудал, амралтын газар, жуулчны баазуудад орчны тохижилтийг сайжруулах, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх чиглэлээр уриалга гарган хүргүүлж хамтарч ажиллах.	Аж ахуйн нэгжийн тоо	-	50	"Тохижилт-Бүтээн байгуулалтын жил"-ийн хүрээнд Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлдэг аялал жуулчлалын байр сууцаар хангах үйлчилгээний байгууллагуудын орчны тохижилтыг сайжруулах, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх чиглэлээр 418 зочид буудал, дэн буудал, 187 амралтын газар, жуулчны баазуудад 2024 оны 04 сарын 05-ны өдрийн "Хаврын их цэвэрлэгээ" нэгдсэн арга хэмжээнд оролцох тухай" 01/125 дугаартай албан бичиг, 2024 оны 04 сарын 30-ны өдрийн "Уриалга хүргүүлэх тухай" 01/165 дугаартай албан бичгийг хүргүүлж, 120 гаруй аж ахуйн нэгж, байгууллага орчиндоо тохижилт хийж, зүлэг, мод, бут сөөг тарьж ногоон байгууламжаа нэмэгдүүлсэн.	04/02-12/10	100
8.	Арга хэмжээ 2.8. Амралтын газар, жуулчны баазуудын гадна орчны тохижилт, бие засах газруудыг үндэсний болон хотын стандартын дагуу шинэчлүүлэх ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулах.	Аж ахуйн нэгжийн тоо	-	-	"Амралтын газар, жуулчны баазын гадна болон дотоод орчны тохижилт, зохион байгуулалтад тавигдах ерөнхий шаардлага UCS1203:2022", "Нийтийн бие засах газрын төлөвлөлт байгуулалтад тавих техникийн шаардлага" UCS1401B:2022", "Хог хаягдлыг цуглуулах, ангилах, хадгалах, тээвэрлэх арга зүйн менежмент" UCS1706A:2022" хотын стандартуудыг "Улаанбаатар хотын амралтын газар, жуулчны баазуудын нэгдсэн мэдээ, мэдээлэл" нэгдсэн цахим хуудсаар дамжуулан сурталчилж, 76 амралтын газар, жуулчны баазад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн.	02/02-12/10	100

					Дээрх судалгааг Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам, НЗДТГазарт хүргүүлсэн. Мөн Монголд ирж байгаа гадаад зочдыг зочид буудал, дэн буудлуудын захиргаатай хамтран бүртгэх ажлыг зохион байгуулах зорилгоор Гадаадын иргэн, харьяатын газарт хүргүүлсэн.		
4	Арга хэмжээ 3.4. Нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлж байгаа амралтын газар, жуулчны баазуудын судалгааг тухай бүр шинэчлэн хөтлөх, холбогдох байгууллагад судалгаа мэдээллийг хүргүүлэх.	Судалгааны гүйцэтгэлийн хувь	100	100	Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлж байгаа амралтын газар, жуулчны баазуудын судалгааг шинэчлэн гаргасан. Нийт 196 амралтын газар, жуулчны бааз байгаагаас НД-140, ХУД-6, БЗД-17, ЧД-9, СХД-10, СБД-9, БНД-2, БХД-1 Дээрх судалгааг Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам, НЗДТГазарт хүргүүлсэн. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд Монгол улсын Засгийн газрын 2022 оны 200 дугаар тогтоолоор батлагдсан "Мэдээлэл хариуцагчаас нээлттэй өгөгдөл бий болгох, нийтлэхэд тавигдах шаардлага, ашиглах нөхцөл, журам"-ын дагуу Засгийн газрын 2022 оны 232 дугаар тогтоолоор батлагдсан нээлттэй өгөгдлийн жагсаалтын дагуу Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлж байгаа амралтын газруудын мэдээллийг www.opendata.gov.mn сайтад байршуулсан.	01/02-12/20	100
5	Арга хэмжээ 3.5. https://www.ulaanbaatar.mn/ портал системийн Үйлчилгээ эрхлэх бүртгэл "Онлайн бизнес төв" цахим системээр ирүүлсэн хүсэлтийн тайланг гарган холбогдох газарт тайлагнах.	Тайлангийн гүйцэтгэлийн хувь	100	100	"Онлайн бизнес төв"-ийн үйлчилгээний тоон мэдээллийг 7 хоног бүрийн тогтсон хугацаанд загвар хүснэгтийн дагуу гарган НЗДТГ-ын Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвд тайлагнасан.	01/02-06/20	100

Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт

Д/д	Үүрэг даалгавар (арга хэмжээ)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
1.	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 1.	Гүйцэтгэлийн хувь	-	100	Жуулчдын аюулгүй байдлыг хангах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд иргэд, олон	02/02-02/07	100

	"АЮУЛГҮЙ УЛААНБААТАР" төсөлд санал боловсруулж хүргүүлэх.				нийтийн оролцоог нэмэгдүүлэх зорилготой НЦУГ-аас боловсруулсан "АЮУЛГҮЙ УЛААНБААТАР" төсөлд санал боловсруулж хүргүүлсэн.		
2.	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 2. Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй 3-аас дээш одны зэрэглэлтэй зочид буудлын судалгаа шинэчлэн гаргах. Удирдах ажилтнуудын уулзалт зохион байгуулах.	Гүйцэтгэлийн хувь	-	100	Монгол улсын Засгийн газраас 2023-2025 оныг "Монголд зочлох жил" болгон зарласантай холбогдуулан НЗД-ын эдийн засаг, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч П.Сайнзориг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дарга Л.Хосбаяр нар Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлж буй 3-аас дээш одтой зочид буудлуудын удирдлагууд, Монголын зочид буудлын холбооны төлөөлөлтэй аялал жуулчлал, зочид буудал, хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газруудад жуулчид болон дотоодын хэрэглэгчийн эрэлт хэрэгцээ, тав тух, аюулгүй байдлыг хангасан, соёлтой шинэлэг үйлчилгээг бий болгох санал солилцох зорилгоор 2024 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр Хангарди ордны 14 давхрын төлөөлөгчдийн танхимд уулзалт зохион байгууллаа. Уулзалтад 3-аас дээш одны зэрэглэлтэй 32 зочид буудлын захирал удирдах ажилтнууд оролцсон.	01/16	100
3.	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 3. "Монголд зочлох жил"-ийн хүрээнд 2024 онд Нийслэл улаанбаатар хотод хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө"-ний төсөл боловсруулах.	Боловсруулсан төслийн тоо	1	1	"Монголд зочлох жил"-ийн хүрээнд 2024 онд Нийслэл улаанбаатар хотод хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний төсөл боловсруулж газрын даргад танилцуулсан.	01/16-02/10	100
4.	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 4. Тайлан гаргаж, тайлагнах.	Тайлангийн тоо	1	1	Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах мастер төлөвлөгөөний биелэлтийг гарган тайлагнасан.	05/16	100
5.	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 5. Олон нийтийн арга хэмжээнд оролцох.	Арга хэмжээний тоо	1	2	Цас цэвэрлэгээнд 2 удаа, "Хаврын их цэвэрлэгээ" нэгдсэн арга хэмжээнд 2 удаа, мод тарих өдрийн арга хэмжээнүүдэд оролцсон.	01/02-06/20	100
6.	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 6. "Буддизм ба байгаль хамгаалал" нэгдсэн арга хэмжээнд оролцох.	Арга хэмжээний тоо	1	1	Налайх дүүргийн ЗДТГ-аас 2024 оны 05 дугаар сарын 22-ны өдөр зохион байгуулсан "Буддизм ба байгаль хамгаалал" нэгдсэн арга хэмжээнд оролцсон.	05/22	100
7.	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 7. НЗДТГ-ын НҮНТөвөөс шаардсан мэдээллийг бэлтгэх хүргүүлэх.	Арга хэмжээний тоо	1	1	https://www.ulaanbaatar.mn/ портал системийн "Онлайн бизнес төв"-ийн зочлох үйлчилгээний асуулт хариулт мэдээллийг шинэчилсэн.	06/22	100

8.	Улаанбаатар хотын захирагч болзошгүй гамшгийн үед түр орон байраар ашиглах барилга байгууламжийн судалгаа гаргах, холбогдох газарт хүргүүлэх.	Арга хэмжээний тоо	1	1	Гамшгаас хамгаалах тухай хуульд заасны дагуу нийслэлд түр орон байраар ашиглах барилга байгууламжийн судалгаа шинэчлэн 87 байгууллагын мэдээллийг НЗДТГазарт хүргүүлсэн.	06/22-12/10	100
9.	Үндэсний их баяр наадмыг үзэх жуулчдад зориулсан тасалбарыг хуваарилах.	Арга хэмжээний тоо	1	1	Үндэсний их баяр наадмыг үзэх жуулчдад зориулсан тасалбар хуваарилах ажлыг зохион байгуулсан. Мөн жуулчдад мэдээлэл зөвлөгөө өгөх, жуулчдын секторт хяналт тавих ажлыг багийн гишүүдтэй хамтран хийсэн. Жуулчдад зориулсан 2204 тасалбар, 100 автомашины зөвшөөрлийг 216 аж ахуй нэгжид хуваарилан тараасан.	07/01-07/13	100

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
1.	Арга хэмжээ 1. Хариуцсан чиглэлийн дагуу сургалт, уулзалт семинарт, зөвлөгөөнд хамрагдах.	Үйл ажиллагааны тоо	1	3	НЗДТГазрын Хүний нөөцийн хөгжлийн төвөөс зохион байгуулсан “Excel” программын сургалт, Худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтны сургалт, ТАЗөвлөлөөс зохион байгуулдаг 4 удаагийн онлайн сургалтад, байгууллын дэргэдэх ёс зүйн зөвлөлөөс зохион байгуулсан сэтгэл зүйн 3 удаагийн сургалтад хамрагдсан.	01/02-06/20	100
2.	Арга хэмжээ 2. Хууль тогтоомж, дүрэм, журмыг уншиж судлах.	Судалсан хууль тогтоомж, дүрэм, журмын тоо	1	3	“Аялал жуулчлалын тухай” хуулийн шинэчилсэн найруулга, НИТХурлын 2022 оны 05 дугаар сарын 30-ний өдрийн 34 дүгээр тогтоолоор батлагдсан “Нийслэлийн нутаг дэвсгэрт худалдаа, үйлчилгээ эрхлэх нийтлэг журам”, “Амралтын газар, жуулчны бааз, гэр буудалд тавих ерөнхий шаардлага” MNS6043:2019,	01/02-06/20	100


				"Амралтын газар, жуулчны баазын гадна болон дотоод орчны тохижилт, зохион байгуулалтад тавигдах ерөнхий шаардлага UCS1203:2022", "Аялал жуулчлал. Дэн буудлын ерөнхий шаардлага MNS 5738:2007" стандартуудыг уншиж судалсан.		
--	--	--	--	--	--	--

ТАЙЛАН ГАРГАСАН:

АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН БАЙГУУЛЛАГУУД,

ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, СТАНДАРТ ХАРИУЦСАН

МЭРГЭЖИЛТЭН Д.ОЮУН-ЭРДЭНЭ /



2024 12 09.

